БАТЛАВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Х.ЭНХТАЙВАН

2024 оны 03 дугаар сарын 24

# ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 03 дугаар сарын 24 Гучин-Ус сум

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Төсөв | Хугацаа | Хариуцсан нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | |
| 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк) мөн мэдээллийн самбарт байршуулах хэлбэрээр олон нийтэд хүргэх. | Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа газар нэгжийг хамруулсан тоо | - | 500 иргэнээс доошгүй | 200.0 | 2-4 дүгээр улирал | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн, Архив, бичиг хэргийн ажилтан |
| 1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг төрийн байгууллага, ажилтан албан хаагчдад зохион байгуулах. | Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо | - | Нөлөөллийн 2 арга хэмжээг зохион байгуулах | 100.0 | 2-4 дүгээр улиралд | Засаг даргын Тамгын газрын дарга |
| **Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах сургалтад хмаруулах** | | | | | | |
| 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Шинээр томилогдсон албан хаагчдыг | - | Тухай бүр | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 2.2. Төрийн байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах | Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо | - | 2 доошгүй арга хэмжээ зохион байгуулах | - | 2-4 дүгээр улирал | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн Архив, бичиг хэргийн ажилтан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| арга хэмжээг зохион байгуулах | | | | | | |
| **Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох** | | | | | | |
| 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээр авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх | Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо | 4 төрлийн гэрээнд | Гэрээ байгуулагдах бүрт | - | 2-4 дүгээр улиралд | Засаг даргын Тамгын газрын дарга |
| **Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах** | | | | | | |
| 4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх г.м) | Цахимжуулсан үйлчилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | - | 2-3 дугаар улирал | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн |
| 4.2. Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Сэтгэл ханамжийн судалгаа авах | - | 2-3 дугаар улирал | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн,<br><br>Архив, бичиг хэргийн ажилтан |
| **Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх** | | | | | | |
| 5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах | Төлөвлөгөө болон тайлан боловсруулж танилцуулснаар | АТҮХ Авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө, тайлан | Нийт албан хаагчдад танилцуулсан байна. | - | 2-4 дүгээр улирал | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрэмд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Тухай бүр | | 2-4 дүгээр улирал | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн |
| **Зорилт 6. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах** | | | | | | |
| 6.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалт зөрчсөн | Хяналт шалгалтын тоогоор | - | Хяналт шалгалт зохион байгуулсан байна | - | 2-4 дүгээр улирал | Засаг даргын Тамгын газрын дарга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлэгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг арилгах | | | | | | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн |
| 6.2. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хүүхэд залуучуудад шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах | Сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо | - | Сургалт зохион байгуулсан байна. | 100.0 | 2-4 дүгээр улиралд | Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн,<br><br>Нийгмийн бодлогын мэрэгжилтэн |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ТУНГАЛАГ

9045376 СБТ 24449 1024030016

# ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 10 Гучин-Ус сум

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Төсөв мян. төгрөг | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | |
| | | | | | | |
| 1.1. Авлиагтай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх. | Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо,<br>Харьяа газар нэгжийг хамруулсан тоо | Хандалт 629 | 500 иргэнээс доошгүй | - | Авлиагтай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, цахим гарын авлагыг сумын веб хуудас, Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудаст нийтлэн иргэдэд тухай бүр хүргэсэн. Хандалт тоо 1012. | 100 |
| 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах. | Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо | 1 арга хэмжээ зохион байгуулсан<br><br>“АЭҮА-ны тайлан-2022 | Нөлөөллийн 2 арга хэмжээг зохион байгуулах | - | “Авлигын эсрэг нэгдье” аяны хүрээнд төрийн албан хаагчдад Авлигатай тэмцэх хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн талаар сургалт хийсэн. | 100 |
| 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах. | Шинэчилсэн мэдээллийн тоогоор | 13 | Сар бүр шинэчлэх | 20.0 | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулан тухай бүр 8 мэдээллийг шинэчлэн байршуулсан. | 90 |
| Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 4 албан хаагч | Шинээр томилогдсон албан хаагчдыг | - | Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн 1 иргэнийг Төрийн зөвлөлийн салбар зөвлөлийн Нэр дэвшүүлэх тухай тогтоолыг үндэслэн томилж, авлигын эсрэг сургалтад хамрууулсан. | 100 |
| 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо | - | 2 доошгүй арга хэмжээ зохион байгуулах | - | Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор цахим болон цаасаар гарын авлага тараасан. Шинээр томилогдсон 3 албан хаагчийн ХАСУМ-ыг хянуулж, төсөвт байгууллагын 3 дарга, 2 нягтлан бодогч, сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч, байгаль орчны хяналтын улсын байцаагч гэсэн 7 албан хаагчдын хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргасан | 100 |
| Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | | |
| 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо | 4 төрлийн гэрээнд | Гэрээ байгуулагдах бүрт | - | Сумын цэвэр усны шугамын, Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны материал нийлүүлэх, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх, Эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэх, Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх, Гүний 2ш худаг гаргах, Аргалант 3 дугаар багийн төвийг засварлах тендерүүдийг зарлан тендер бүрт Засаг даргын захирамжаар Үнэлгээний хороо байгуулан гишүүн бүрээр батлагааны маягт, ашиг сонирхлын зөрчилгүй | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан ажилласан. Ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авах гэрээ байгуулах бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулсан. | |
| Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах. | | | | | | |
| 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Цахимжуулсан үйлжилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | - | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон шилэн ажиллагааны хүрээнд нийтэд мэдээллэхээр заасан 68 мэдээллээс 56 мэдээллийг тухай бүр shilen.gov.mn-д ... хувьтай үнэлэгдэж, тухай бүрийн мэдээ, мэдээллийг manage.gov.mn-д нийтэлж ил тод байдлыг хангасан. | 100 |
| 4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх. | Хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан тоо | - | Сэтгэл ханамжийн судалгаа авах | - | Сумын Засаг даргын захирамжийн дагуу төрийн 5 байгууллагад хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байгууллага бүрийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд хяналт, шалгалт хийж албан хаагчдад авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | | | |
| 5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах. | Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар | АТҮХ, Авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө, тайлан | Нийт алба хаагчдад танилцуулсан байна | - | Авлигын эсрэг үйл ажиллагааны сумын төлөвлөгөөг боловсруулж сумын албан ёсны веб хуудаст байршуулан хагас, бүтэн жилээр тайлагнагнан албан хаагчдад хүрсэн түвшин, биелэлтийн талаар тайлагнасан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 6. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах. | | | | | | |
| 6.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлэгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг арилгах | Хяналт шалгалтын тоогоор | - | Хяналт шалгалт зохион байгуулсан байна | - | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө оруулгын мэдүүлгийг 7 албан хаагчаас хугацаанд нь авч тайлагнасан. Авлигатай тэмцэх Шуур ажиллагааны хүрээнд төрийн 6 байгууллагын томилгоо, шийдвэрт хяналт шалгалтыг хийхэд ашиг сонирхлын зөрчил илрээгүй. | 100 |
| 6.2. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хүүхэд залуучуудад шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах | Сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо | 2 удаагийн арга хэмжээ | Сургалт зохион байгуулсан байна. | 100.0 | Төрийн байгууллагуудыг дарга нар болон ХАСХОМ, ХАСУМ-ын мэдүүлэг гаргах албан хаагчдад 2 удаа авлигын эсрэг сургалтыг хийж оролцогчдод гарын авлага тараасан. Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 насны хүүхдүүдийн дунд соён гэгээрүүлэх сургалтыг хийж 78 хувийн ирцтэй оролцсон. | 100 |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | **98** |

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА Х.ЭНХТАЙВАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ТУНГАЛАГ

9045376 СБТ 24449 1024030016